

III. Таван Толгойн уурхайн тээвэрлэлт

Симуляци 3


Энэхүү симуляци нь Таван Толгой нүүрсээ экспортлохдоо уламжлалт тээврийн үйлчилгээнээс төмөр зам руу шилжих шилжилтийг харуулна.

Төмөр замын салбарт хөрөнгө оруулалт хийгдсэнээр:

- Төмөр замын үйлчилгээ харьцангуй хямд болох
- Төмөр замыг ашиглахад үнийн бус давуу тал бий болох

Шинэ салбар/бүтээгдэхүүн -Таван Толгойн нүүрс

Таван Толгойн нүүрсний үйлдвэрлэл, экспорт (сая тонн)



Эх сурвалж: Ашигт Малтмал Газрын тосны Газар, Компаниудын мэдээлэл

Таван толгойн нүүрс:

1. Нийт нүүрсний үйлдвэрлэлийн 52%;
2. Зардлын бүтэц нь том нүүрсний салбартай ижил;
3. Дотооддоо нийлүүлдэггүй, зөвхөн экспортолдог;
4. Нийт нүүрсний экспортын 58%.

Шинэ салбар/бүтээгдэхүүн – Төмөр зам

1. Нийт тээврийн салбарын 0.28 хувь.
2. Зардлын бүтэц нь том тээврийн салбартай ижил.
3. Төмөр зам нь маржин бүтээгдэхүүн.
4. Таван Толгой нүүрсээ экспортлохдоо төмөр зам болон уламжлалт тээврийн үйлчилгээг хоёуланг нь ашигладаг.
5. SAM дахь Таван Толгойн нүүрсний тээврийн нийт маржин (75 тэрбум төгрөг).
6. Үүний 10% нь төмөр замд оногдоно (7.5 тэрбум төгрөг).

Загварт хийсэн өөрчлөлт

Шинэ нийлмэл бүтээгдэхүүн: TT_Trans ($Trans_m$ болон $Rail_m$)

$$TT_Trans = tr_c EXD('coal') \quad (1)$$

$$tr_c = \frac{TT_Trans_0}{\sum_j EXO(j, 'coal')} = \frac{Trans_m_0 + Rail_m_0}{\sum_j EXO(j, 'coal')} \quad (2)$$

$$PC_{TT_Trans} = \frac{[PC('trans') * Trans_m + PC('rail') * Rail_m]}{TT_Trans} \quad (3)$$

Загварт хийсэн өөрчлөлт

$$TT_Trans = B^{TR} \left[\beta^{TR} (A_{Trans}^{TR} Trans_m)^{-\rho^{TR}} + (1 - \beta^{TR}) (A_{Rail}^{TR} Rail_m)^{-\rho^{TR}} \right]^{-\frac{1}{\rho^{TR}}} \quad (4)$$

$$\rho^{TR} = \frac{1 - \sigma^{TR}}{\sigma^{TR}} \quad (5)$$

$$\frac{Trans_m}{Rail_m} = \frac{A_{Rail}^{TR}}{A_{Trans}^{TR}} \left[\frac{PC('trans')(1 - \beta^{TR})}{PC('rail')\beta^{TR}} \right]^{-\sigma^{TR}} \quad (6)$$

Загварын хаалтын нөхцөл (Closures)

Экзоген хувьсагчид:

- Нэрлэсэн валютын ханш - e
- Засгийн газрын зардал - G
- Хөдөлмөрийн нийлүүлэлт - $LS(I)$
- Урсгал тэнцэл - CAB
- Импортын бүтээгдэхүүний дэлхийн үнэ - $PWM(i)$
- Экспортын бүтээгдэхүүний дэлхийн үнэ - $PWX(i)$
- Бүх салбарын капиталын нөөц - $KD(j)$
- Шилжүүлэгч (үр ашгийн) хувьсагчид - A_{trans}^{TR} , A_{rail}^{TR}

Симуляци

Үнийн бууралтын нөлөө: Төмөр замын үйлчилгээний үнэ буурах нь Таван Толгой төмөр замыг илүүтэй ашиглахад нөлөөлнө.

Үнийн бус давуу тал: Таван Толгой нүүрсээ экспортлохдоо төмөр замыг ашиглах нь илүү үр ашигтай болж, төмөр замыг илүүтэй ашиглаж эхэлнэ.

Орлуулалтын мэдрэмж:

$$\sigma^{TR} = 20$$

Төмөр замын салбарын
капиталын нөөц:

$$KD('rail') * 13$$

Шилжүүлэгч хувьсагч:

$$A_{rail}^{TR} = 1.1$$

Симуляцийн үр дүн

Хувьсагч	Анхны утга	Шокын дараах утга	Өөрчлөлт (%)
Нийлмэл тээврийн бүтээгдэхүүний үнэ	1.0	0.9	-13.5
Төмөр замын үйлчилгээний үнэ	1.0	0.8	-15.4
Уламжлалт тээврийн үйлчилгээний үнэ	1.03	1.01	-0.1
ТТ-н нийлмэл тээврийн үйлчилгээний эрэлт	73,398.0	73,962.8	0.8
ТТ-н төмөр замын үйлчилгээний эрэлт	7,509.0	72,049.2	859.4
ТТ-н уламжлалт тээврийн үйлчилгээний эрэлт	65,888.0	4,428.2	-93.3
Уламжлалт тээврийн салбарын үйлдвэрлэл	2,644,488.5	2,602,738.2	-1.6
Төмөр замын салбарын үйлдвэрлэл	7,510.5	72,499.5	865.3
Бодит ДНБ	20,020,864.0	20,038,276.8	0.1

Дүгнэлт

- Уламжлалт тээврийн үйлчилгээнээс төмөр зам руу шилжих шилжилтийг харуулах үүднээс зөвхөн Таван Толгойн нүүрсний экспортод ашиглагдах нийлмэл тээврийн маржин бүтээгдэхүүн оруулж загварт өргөтгөл хийлээ.
- Төмөр замд хөрөнгө оруулалт хийгдсэнээр үнийн болон үнийн бус хүчин зүйлийн нөлөөгөөр энэхүү шилжилт явагдаж байгааг симуляцийн үр дүн харуулж байна.

**Анхаарал тавьсанд
баярлалаа**